

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН
2024 ОНЫ III ДУГААР УЛИРЛЫН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН**






2024 оны 10 дугаар сарын 09

Номгон

Баянхонгор аймгийн 2024 оны төсвийн ерөнхийлөн захирагчийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тодотгон батлагдсан төлөвлөгөөнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 13 нэр төрлийн 34,9 тэрбум, урсгал төсвөөр 2 нэр төрлийн 47.8 сая төгрөгийн, орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 87 нэр төрлийн 19,3 тэрбум төгрөгийн, нийт 102 нэр төрлийн 54,2 тэрбум төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөгдсөн байна.

2024 оны III дугаар улирлын байдлаар холбогдох сумуудад 7,4 тэрбум төгрөгийн 40 төсөл арга хэмжээний эрхийг шилжүүлж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 13 нэр төрлийн 34,9 тэрбум, урсгал төсвөөр 2 нэр төрлийн 47,8 сая төгрөгийн, орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалттай 8.1 тэрбум төгрөгийн 37 төсөл арга хэмжээ, нийт 52 нэр төрлийн 43,1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг 100% цахим хэлбэрээр зохион байгуулж, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тодотгосон төлөвлөгөө 96%-ийн биелэлттэй явагдаж байна.

Дээрх нийт тендер нь зарлагдсан төсөл, арга хэмжээг холбогдох хууль,, журмын дагуу зохион байгуулж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаас 978,5 сая төгрөг, орон нутгийн төсвийн батлагдсан хөрөнгө оруулалтаас 274,1 сая төгрөг, нийт 1,2 тэрбум төгрөгийн төсвийн хэмнэлтийг гарган ажиллаа. Тайлант хугацаанд зохион байгуулагдсан төсөл, арга хэмжээний явцыг ангилбал:

-  Холбогдох сумдад эрх шилжүүлсэн 40 буюу 7.4 тэрбум төгрөг-39.2%
-  Тендер нь зарлагдсан 1 буюу 95.0 сая төгрөг-1.0%
-  Гэрээ байгуулагдсан -52 буюу 43.1 тэрбум төгрөг-50.9%
-  Үнэлгээний шатандаа яваа- байхгүй.
-  Тендер нь зарлагдаагүй буюу ажлын даалгавар, ТЭЗҮ ирүүлээгүй төсөл арга хэмжээ-8 буюу 2,9 тэрбум төгрөг-7.8%-ийг тус тус эзэлж байна.

(Хүснэгтээр гаргасан тайланг хавсаргав)

Худалдан авах ажиллагааны ил тод байдлын хүрээнд:

Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах үүднээс улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх бүх төрлийн тендер шалгаруулалтын зарлалыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем

болох tender.gov.mn- д нийтэлж, төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, урилга, үр дүн, аудитын тайлан дүгнэлт, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн байдал зэрэг худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллүүдийг [https://bayanhongor.gov.mn/-д](https://bayanhongor.gov.mn/) байршуулан ажиллаж байна.

Мөн [https://shilendans.gov.mn/-д](https://shilendans.gov.mn/) Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, Худалдан авах ажиллагааны тайлан, Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн зэргийг тухай бүр цаг хугацаанд нь оруулж ажиллаа.

Мэргэжил арга зүйгээр хангах хүрээнд :

2024 оны 10 дугаар сарын 05-06-ны өдрүүдэд аймгийн “Худалдан авах ажиллагааны газар”-с Төрийн худалдан авах ажиллагаанд мэргэшүүлэх "АЗ" сертификат олгох сургалтыг “Худалдан авах ажиллагааны сургалт судалгааны төв” ТББ-тай хамтран зохион байгууллаа. Сургалтанд төрийн алба, төрийн бус байгууллага, иргэд, аж ахуйн нэгжүүдийн төлөөлөл нийт 75 хүн хамрагдан, 29 хүн шалгалтанд тэнцэж, шинээр төрийн худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх сертификат авлаа. Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд захиалагчийн эрх үүсгэсэн төсвийн байгууллагууд болон сумдын худалдан авах ажиллагаа зохион байгуулдаг эрх бүхий албан тушаалтнуудад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон түүнтэй холбогдон гарсан эрх зүйн актууд, цахим системээр худалдан авах ажиллагааг зохион байгуулах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөөг тухай бүр өгч ажилласан.

Тендерт оролцогчдыг мэдээллээр хангах хүрээнд :

Тендерт оролцогч аж ахуйн нэгжүүд болон оролцохыг сонирхсон этгээдүүдэд цахим системээр тендерийн материал хэрхэн илгээх, хэрхэн худалдан авах ажиллагааны цахим системд бүртгүүлэх, тоон гарын үсгийг хэрхэн ашиглах, худалдан авах ажиллагаатай холбогдон гарсан асуудлуудад тухай бүр заавар, зөвлөгөө өгч ажилласан ба 2024 оны 09 дүгээр сарын байдлаар шинээр 13 аж ахуйн нэгжид тоон гарын үсэг олгож, 5 аж ахуйн нэгжийн тоон гарын үсгийг сунган ажиллаа.